

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2016 оны 6 дугаар  
сарын 30-ний өдөр

Дугаар ~~162.1.195~~

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 36.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 312 дугаар тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 253 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр), Хяналт шалгалтын газар (Д.Ганбат), Санхүүгийн мэдээллийн алба (Б.Төмөрбат), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Ц.Нацагдорж)-т тус тус үүрэг болгосугай.





## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (цаашид МУТС гэх)-ээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой эрсдэлд суурилсан тогтолцоог мэдээлэх үүрэгтэй этгээдэд бий болгоход оршино.

1.2 Энэ журамд орсон дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1 “Мэдээлэх үүрэгтэй этгээд” (цаашид МэҮЭ гэх) гэж МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан этгээдийг;

1.2.2 “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээдийг;

1.2.3 “Корреспондент банкны харилцаа” гэж нэг банк (корреспондент) нь өөр банкуудын (респондент) мэдлийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг байршуулан, тэдгээрт мөнгөн хөрөнгийн удирдлагын үйлчилгээ, төлбөр тооцоо, чек, клиринг, валют солих зэрэг олон төрлийн үйлчилгээ;

1.2.4 “Хуулийн этгээд” гэж “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.1-д заасан этгээдийг;

1.2.5 “Тохиолдлын гүйлгээ” гэж данс нээлгээгүй эсхүл тогтвортой бизнесийн харилцаа үүсгээгүй этгээдийн нэг удаагийн шинжтэй гүйлгээг;

1.2.6 “Цахим шилжүүлэг” гэж шилжүүлэгч этгээдийн хүсэлтийн дагуу түүний нэрийн өмнөөс банк, санхүүгийн байгууллага мөнгийг цахим орчинд дотоод, гадаадын нэг эсхүл хэд хэдэн банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан хүлээн авагчид хүргэхийг;

1.2.7 “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад болон гадаад улсад үйлдсэн гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанаас шууд болон шууд бусаар олсон эд хөрөнгө, ашиг болон орлогыг.

### ХОЁР. МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 МэҮЭ нь өөрт учирч болох МУТС эрсдэлийг тогтмол үнэлж, түүнд тулгуурлан эрсдэлийг удирдах, бууруулахад чиглэсэн оновчтой, үр дүнтэй урьдчилан сэргийлэх, тэмцэх дотоод бодлого, журам болон хөтөлбөрийг баталж, мөрдөж ажиллана.

2.2 МэҮЭ нь дотоод хяналтын хөтөлбөрөө<sup>1</sup> МУТС эрсдэлийн эсрэг оновчтой хариу үйлдэл үзүүлж буй эсэхийг тогтмол нягталж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болон тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, газар зүйн байршил болон харилцагчийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохистой арга хэмжээ авахтай холбогдуулж тус хөтөлбөрийг тогтмол шинэчилнэ.

2.3 Эрсдэлийн үнэлгээг хийхэд МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.8 болон 6 дугаар зүйлд заасан өндөр эрсдэлтэй бизнесийн харилцаа, гүйлгээтэй нийцүүлэхийн зэрэгцээ дор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

2.3.1 Харилцагчаас хамаарах эрсдэлийн хүчин зүйлс:

2.3.1.1 энгийн бус нөхцөлд үүсгэсэн бизнесийн харилцаа (Жишээлбэл: биечлэн ирэлгүй зайнаас үүсгэсэн бизнесийн харилцаа);

2.3.1.2 оршин суугч бус харилцагч;

2.3.1.3 харилцагч нь хуулийн этгээд эсхүл гэрээ, хэлцэлийн дагуу хэн нэгний хөрөнгийн удирдлагыг хариуцаж байгаа этгээд;

2.3.1.4 хэвийн бус эсхүл ойлгоход төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд, хуулийн этгээд нь өөрийн хувьцаа эзэмшигч, хувьцааны шилжилт хөдөлгөөний бүртгэдэггүй, хувьцаа эзэмшигч болохыг нотлох нэр бичээгүй үнэт цаасыг эзэмшиж байгаа этгээд хувьцаа эзэмшигч байх (bearer share) зохицуулалттай хуулийн этгээд эсхүл кастодиан гэрээний дагуу хувьцааны эцсийн өмчлөгчийн өмнөөс хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчтэй (nominee share) хуулийн этгээд бол.

2.3.2 Газар зүйн эрсдэлийн хүчин зүйлс:

2.3.2.1 МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй улс орнууд;

2.3.2.2 санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалт болон ижил төстэй арга хэмжээнд хамрагдсан улс орнууд;

2.3.2.3 авлига, хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй улс орнууд;

2.3.2.4 тухайн улс орон эсхүл бүс нутаг нь терроризмыг санхүүжүүлдэг, террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг эсхүл террорист бүлэглэл тэнд үйл ажиллагаа явуулдаг талаар баттай эх сурвалж байгаа эсэх.

2.3.3 Бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон гүйлгээний эрсдэлийн хүчин зүйлс:

2.3.3.1 хувийн болон тусгай банкны үйлчилгээ;

2.3.3.2 хүлээн авагчийн нэр тодорхой бус бэлэн мөнгөний болон бусад гүйлгээ;

2.3.3.3 биечлэн ирээгүй зайнаас үүсгэсэн бизнесийн харилцаа болон гүйлгээ;

2.3.3.4 үл мэдэгдэх эсхүл хамааралгүй гуравдагч этгээдээс хийгдсэн төлбөр тооцоо болон бусад гүйлгээ.

2.3.4 Данс болон санхүүгийн харилцааны зорилго;

2.3.5 Гүйлгээнээс үүдэх эрсдэлийн хүчин зүйлс (үүнд харилцагчийн гүйлгээний болон байршуулж байгаа хөрөнгийн хэмжээ, гүйлгээний давтамж болон санхүү, бизнесийн харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн хугацаа, гүйлгээний утга, хэмжээ огцом өөрчлөгдсөн эсхүл өндөр эрсдэлтэй улсаас хийгдсэн, дамжсан зэргийг анхаарна);

2.3.6 МэҮЭ болон түүний бизнесийн харилцаанд тулгарч болох бусад эрсдэлийн хүчин зүйлс.

---

<sup>1</sup> МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хөтөлбөр

2.4 МэҮЭ нь эрсдэлийн үнэлгээ болон түүнтэй холбоотой мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчилэн, баримтжуулж хянан шалгагчийн хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтайгаар хадгална.

#### ГУРАВ. МУТС ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ХӨТӨЛБӨР

3.1 МэҮЭ нь эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1.1 харилцагч, эцсийн өмчлөгч, ашиг хүртэж буй этгээд болон гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл гаргуулан авах;

3.1.2 харилцагчийн эрсдэлийн хувийн хэргийг бүрдүүлэх (хувийн хэрэг нь харилцагчийн талаар хангалттай мэдээллийг агуулахын зэрэгцээ харилцагчийн МэҮЭ-тэй үүсгэсэн санхүү, бизнесийн харилцааны мөн чанар зорилго, хөрөнгө, орлогын эх үүсвэрийн талаарх мэдээллийг агуулсан байна);

3.1.3 өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон газарзүйн байрлалтай уялдуулан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нарийвчлан хийж гүйцэтгэнэ;

3.1.4 харилцагчтай үүсгэсэн санхүү, бизнесийн харилцаа болон гүйлгээг байнгын хяналтанд байлгаж харилцагчийн хувийн хэрэг болон харилцагчийн талаарх холбогдох мэдээлэлд тулгуурлан харилцагчийн гүйлгээг нягтална. Хэрэв шаардлагатай бол гүйлгээний төрөл, хэмжээ, утгын хязгаарлалтыг тогтоож гүйлгээний хэв шинж өөрчлөгдөж байгаа эсэхийг хянаж болно.

3.2 МэҮЭ нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, удирдлага эсхүл удирдах этгээдийн баталсан МУТС эсхүл хууль бус бусад үйлдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор баримтлах дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөртэй байна.

3.3 Энэ журмын 3.2-д дурдсан дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөр нь МэҮЭ-ийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалтад нийцсэн байхын зэрэгцээ МУТС эрсдэлд үндэслэж түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

3.4 МэҮЭ-ийн МУТС-ээс урьдчилан сэргийлэх дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөр нь дотоод, гадаадад байх бүх салбар нэгж, охин компанид нэгэн ижил хэрэгждэг байна.

3.5 МэҮЭ-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороод, бие даасан дотоод хяналтын нэгж нь МУТС-ээс урьдчилан сэргийлэх дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх, МУТС эрсдэлийг оновчтой тодорхойлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.

3.6 МэҮЭ-ийн дотоод хяналтын хөтөлбөрт МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлтэй уялдуулан дараах зүйлсийг тусгана. Үүнд:

3.6.1 МэҮЭ-ийн МУТС эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үзсэн чиглэлээр тусгайлсан сургалтын хөтөлбөр;

3.6.2 МУТС-тэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журмыг хэрэгжүүлэх хүрээнд ажилтнуудад зориулсан гарын авлага, заавар;

3.6.3 хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох ба чөлөөлөх журам болон түүний эрх, үүргийг зохицуулсан журам;

3.6.4 хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь удирдах түвшний ажилтан байх;

3.6.5 хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь МэҮЭ (бүх салбар, нэгж, охин компанийг хамарна)-ийн холбогдох бүх баримт бичиг, тэр дундаа харилцагч болон гүйлгээний талаарх баримт, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнаас гаргуулан авах эрхтэй байх зохицуулалт;

3.6.6 МэҮЭ нь МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагаас хараат бус, ажил үүргээ гүйцэтгэх хангалттай нөөц бололцоогоор хангагдсан дотоод аудитын нэгжтэй байна;

3.6.7 МэҮЭ-ийн хүний нөөцийн бодлого журамд ашиг сонирхлын зөрчилтэй, залилан, луйвар болон шударга бус зан чанарыг илтгэх бусад гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан этгээдийг ажилд авахгүй байх зохицуулалт.

#### ДӨРӨВ. МУТС ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ХАРИЛЦАГЧ БОЛОН ГҮЙЛГЭЭНД ХИЙГДЭХ НАРИЙВЧИЛСАН ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 МэҮЭ нь дор дурдсан тохиолдолд харилцагчийг таньж мэдэх (цаашид ХТМ гэх) үйл ажиллагааг нарийвчлан хийнэ:

4.1.1 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 14.1.4-т заасан эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, гүйлгээнд;

4.1.2 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан гүйлгээ хийх тохиолдолд;

4.1.3 харилцагч биечлэн ирэлгүй зайнаас гүйлгээ хийж байгаа эсхүл харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээд хийсэн тохиолдолд.

4.2 Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авна:

4.2.1 тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;

4.2.2 тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна. Энэ зөвшөөрөл нь ХТМ журмын хүрээнд явагдах бөгөөд уг журамд МэҮЭ-ийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс өндөр МУТС эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах боломжтой зохицуулалтыг оруулсан байх;

4.2.3 харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн, харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авсан мэдээллийг эргэж хянах;

4.2.4 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.3-т болон 19.2.3-д заасан журмуудын харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгахтай холбоотой бусад шаардлагууд.

4.3 Өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагааг бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

#### ТАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ

5.1 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.1, 5.2 дахь заалт болон энэ журмыг хэрэгжүүлэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах үйл ажиллагаа нь Хүснэгт 1-3-т заасан шаардлагын дагуу хийгдэнэ. ХТМ үйл ажиллагааны зорилго нь МэҮЭ өөрийн харилцагч болон түүний МэҮЭ-тэй үүсгэсэн харилцааг удирдан, хянаж байгаа эсхүл үр ашгийг хүртэж байгаа эцсийн өмчлөгчийг таньж мэдэх явдал юм. Эцсийн өмчлөгч нь хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эсхүл хяналтын багцыг нь эзэмшдэг хувь хүн байна. Нэг хуулийн этгээд өөр хуулийн этгээдийг өмчлөх хэлбэрээр үргэлжилсэн холбоо байгаа тохиолдолд холбоос бүрд харгалзах өмчлөлийн бүтцийг тогтоох байдлаар эцсийн өмчлөгч тодорхой болох хүртэл үргэлжлүүлнэ. Гэрээ хэлцлийн үндсэн дээр харилцагч нь бусад хувь хүн хуулийн этгээдийг төлөөлж байгаа тохиолдолд хүснэгт 3-ийн дагуу ХТМ үйл ажиллагааг хийнэ.

5.2 Харилцагч нь хувь хүн бол:

*Хүснэгт 1.*

Харилцагчаас авах мэдээлэл	Нягтлах баримт бичиг <sup>2</sup>
Овог, эцэг/эх/-ийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Өөрийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Төрсөн огноо	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Регистрийн дугаар	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Байнгын оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого, журмаар зохицуулна.
Одоо оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Эрхэлж буй ажил, бизнес: 1.Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах 2.Ажлын газрын нэр хаяг, албан тушаалыг тодруулах	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэхийг тодруулах.	Хэрэв харилцагч нь хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлж байгаа этгээдийн мэдээллийг авна. Төлөөлүүлж байгаа этгээд нь хувь хүн бол Хүснэгт 1, хуулийн этгээд бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гаргуулан авч үнэн бодит эсэхийг нь нягтална.

### 5.3 Харилцагч нь хуулийн этгээд бол:

#### Хүснэгт 2.

Харилцагчаас авах мэдээлэл	Нягтлах баримт бичгүүд <sup>3</sup>
Нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээ
Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээ
Татвар төлөгчийн дугаар	Татварын байгууллагаас олгосон баримт, бичиг
Хувьцаа эзэмшигчид	Улсын бүртгэлийн гэрчилгээ Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, аж ахуйн нэгжийн дүрэм
Үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээ Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, аж ахуйн нэгжийн дүрэм

<sup>2</sup> МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.2.1-т заасны дагуу баталгаажуулсан хуулбарыг харилцагчийн хувийн хэрэгт хадгална.

<sup>3</sup> МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.2.2-т заасны дагуу баталгаажуулсан хуулбарыг харилцагчийн хувийн хэрэгт хадгална.

<b>Хуулийн этгээдийн бүтэц, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга</b>	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
<b>Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар</b>	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг МэҮЭ өөрийн дотоод бодлого, журмаар зохицуулна.
<b>Эцсийн өмчлөгчийн мэдээлэл<sup>4</sup></b>	Хэрэв эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдэд ямар нэг албан тушаал эрхэлдэггүй бол Хүснэгт 1-ийн дагуу бүх мэдээллийг авах ба тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч мөн болохыг нотлох баримтын хамт авна.

5.4 Харилцагч хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол:

### **Хүснэгт 3**

#### **Харилцагчаас авах мэдээлэл**

#### **Нягтлах баримт бичиг**

<b>Хэрэв харилцагч нь хувь хүн бол Хүснэгт 1-т заасан мэдээллийг гаргуулан авна.</b>	Хүснэгт 1-т заасан баримт бичгүүд
<b>Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол: Хүснэгт 2-ын дагуу мэдээллийг гаргуулан авна</b>	Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол Хүснэгт 2-т заасан баримт бичгүүд
<b>Эрх зүйн гэрээгээр төлөөлж байгаа бол гэрээний талуудын улсын бүртгэлийн мэдээлэл, тэр дундаа (i) гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг, бусад бүртгэлийн мэдээллүүд; (ii) төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн эсхүл хуулийн этгээдийн мэдээллүүд; (iii) хөрөнгийн ашгийг хүртэх эрхтэй этгээдийн мэдээлэл.</b>	Гэрээний талуудын мэдээллийг хувь хүн бол Хүснэгт 1, хуулийн этгээд бол Хүснэгт 2-ын дагуу бүрдүүлж үнэн бодит байдлыг нь нягтална.

5.5 МэҮЭ нь харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулан хадгалах үүрэгтэй.

5.6 МэҮЭ нь ХТМ хүрээнд цуглуулсан баримт бичиг, мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодорхой хугацааны давтамжтайгаар нягтлаж шинэчлэх үүрэгтэй.

5.7 МэҮЭ нь дараах тохиолдолд харилцагчийн мэдээллийг дахин нягтална:

5.7.1 харилцагч өндөр дүнтэй гүйлгээ хийх тохиолдолд;

5.7.2 харилцагчийн гүйлгээний төрөл, давтамж, утга, дүн гэх данс, гүйлгээний хэв шинжид өөрчлөлт ажиглагдсан тохиолдолд;

5.7.3 харилцагчийн талаар өмнө нь олж авсан мэдээлэл нь МэҮЭ-д санхүүгийн харилцаа болон гүйлгээний шинж чанарыг тодорхойлоход хангалтгүй байвал.

5.8 Харилцагчийн МэҮЭ-тэй үүсгэсэн харилцаа нь гуравдагч этгээдийг төлөөлөн хийгдэж байгаа эсэхийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авна. Харилцагч гуравдагч этгээдийг төлөөлөн санхүү, бизнесийн харилцаа үүсгэж байгаа бол эцсийн өмчлөгчийг тогтоох,

<sup>4</sup> Энэ мэдээлэл нь хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн хувьд шаардлагагүй.

түүнийг таньж мэдэх боломжит бүх арга хэмжээг авч ажиллана. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг энэ журмын Хүснэгт 1, 2, 3-т заасан шаардлагын дагуу гаргуулан авна.

5.9 ХТМ үйл ажиллагааны хүрээнд харилцагчаас гаргуулан авсан баримт, мэдээлэл нь худал эсхүл хуурамч болох нь тогтоогдсон бол МэҮЭ нь сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлнэ.

5.10 МэҮЭ нь харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах боломжгүй, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс харилцагч татгалзсан тохиолдолд тухайн этгээдэд данс нээх, бизнесийн харилцаа үүсгэх, гүйлгээ хийхээс татгалзана. Өмнө нь үүсгэсэн бизнесийн харилцааг зогсоох арга хэмжээ авч СГ-ний тайлангаар СМА-нд мэдээлнэ.

5.11 МэҮЭ нь хөрөнгө, гүйлгээ эсхүл гүйлгээ хийх оролдлогыг МУТС-тэй холбоотой эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж сэжиглэсэн бөгөөд ХТМ үйл ажиллагааг хийх эсхүл үргэлжлүүлэх нь харилцагчид өөрийг нь сэжиглэж байгаа нь тодорхой болно гэсэн итгэл төрсөн бол ХТМ үйл ажиллагааг зогсоож, нэн даруй СГ-ний тайлангаар СМА-нд мэдээлнэ.

5.12 МэҮЭ нь НҮБ болон дотоодын эрх бүхий байгууллагаас террорист гэж зарласан этгээдэд данс нээх, гүйлгээ хийх санхүүгийн аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

5.13 Харилцагчийн нэр террорист гэж зарласан этгээдийн нэртэй тохирч байвал, МэҮЭ НҮБ болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон нэмэлт мэдээллийг тулган, нягталж тохирч байгаа эсхүл сэжигтэй гэж үзсэн тохиолдолд гүйлгээг түдгэлзүүлж, нэн даруй Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэж гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг 24 цагийн дотор СМА-нд СГ тайлангаар мэдээлнэ.

#### ЗУРГАА. БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ

6.1 МУТСТ тухай хуулийн 8 дугаар зүйлд нийцүүлэн МэҮЭ нь баримт материалыг дараах байдлаар хадгална:

##### Хүснэгт 4

Баримтын төрөл	Хадгалах хугацаа
Харилцагчийн данс нээх, бизнесийн харилцаа үүсгэхэд ашигласан баримт бичиг, харилцагчийг таньж мэдэх хүрээнд олж авсан баримт бичгүүд, биеийн байцаалтын хуулбар.	Данс хаагдсанаас эсхүл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил. Тохиолдлын чанартай гүйлгээ хийсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил.
Харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан баримт, мэдээлэл, харилцагчийн мэдээлэлд орсон өөрчлөлт, нэмэлт баримт, мэдээлэл, дансны мэдээлэл, корреспондент харилцааны гэрээ, санамж, бичиг, МУТС эрсдэлийг тодорхойлоход ашигласан мэдээлэл, харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналтын дүгнэлт, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материал.	Харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил.
Бэлэн болон бэлэн бус гүйлгээний баримтууд	Гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил.

6.2 МУТСТ тухай хууль болон энэ журмын дагуу хадгалах баримт нь тухайн гүйлгээг сэргээх боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байх бөгөөд хуулинд заасан эрх бүхий этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

6.3 Баримт материалыг шүүх үйл ажиллагаанд нотлох баримтын түвшинд ашиглах боломжийг хангаж байхаар архивлаж хадгална.



## ДОЛОО. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭД

7.1 МУТСТ тухай хуулийн 14 дүгээр зүйл болон энэ журмын 3 дугаар зүйлд заасан дотоод хяналтын хөтөлбөр нь улс төрд нөлөө бүхий этгээд, түүний гэр бүлийн гишүүд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, тэдгээрийг ХТМ нарийвчилсан үйл ажиллагаанд хамруулах, тэдгээрийн нэр дээр хийгдэж байгаа гүйлгээнд тусгайлан хяналт тавих арга хэмжээг багтаана.

7.2 МэҮЭ нь МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д зааснаас гадна дараах этгээдийг өндөр эрсдэлтэй этгээд гэж үзэж болно:

а. Гадаад орны Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, улс төрийн өндөр албан тушаалтан, засгийн газар, шүүх, цэрэг армийн өндөр албан тушаалтан, төрийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлагад байсан эсхүл байгаа хувь хүнийг;

б. Олон улсын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, захирал, орлогч захирал байсан эсхүл байгаа хувь хүнийг;

7.3 Улс төрд нөлөө бүхий этгээдийн гэр бүлийн гишүүд, нэгдмэл сонирхолтой этгээдийг улс төрд нөлөө бүхий этгээдтэй адил авч үзнэ.

## НАЙМ. КОРРЕСПОНДЕНТ ХАРИЛЦАА

8.1 МэҮЭ нь гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хил дамнасан корреспондент болон түүнтэй ижил төстэй харилцаа тогтоохоос өмнө дараах арга хэмжээг авах шаардлагатай:

8.1.1 уг банк, санхүүгийн байгууллагын бодитоор оршдог эсэх талаар мэдээлэлтэй болох;

8.1.2 олон нийтэд нээлттэй мэдээллийн эх үүсвэрээс тухайн банк, санхүүгийн байгууллагын нэр хүнд, түүнд хийгддэг хяналт шалгалтын тухай мэдээлэл цуглуулан МУТС гэмт хэрэгт холбоотой шалгагдаж байсан эсэх, хяналт шалгалтын байгууллагаас МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдуулан тухайн банк, санхүүгийн байгууллагад хариуцлага тооцож байсан эсэхийг нягтлах;

8.1.3 корреспондент харилцаа тогтоохын өмнө МэҮЭ-ийн дээд түвшний удирдлагын зөвшөөрлийг авах;

8.1.4 асуулга илгээх байдлаар корреспондент банк, санхүүгийн байгууллагын МУТСТ дотоод хяналтын тогтолцоог үнэлэх;

8.1.5 корреспондент харилцаанаас үүсэх хоёр талын хариуцлагыг тодорхойлсон гэрээ байгуулах;

8.1.6 корреспондент харилцаа үүсгэх банк, санхүүгийн байгууллага нь МэҮЭ дээр байрших дансыг ашиглан шууд гүйлгээ хийх эрхийг өөрийн аль нэг харилцагчдаа зөвшөөрдөг эсэхийг мэдэх, хэрвээ тийм бол уг харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг корреспондент харилцаа үүсгэх банк, санхүүгийн байгууллага нягталсан эсэхийг, түүний гүйлгээнд байнгын хяналт тавьдаг эсэхийг мөн хүсэлт гаргасан тохиолдолд уг харилцагч, түүний гүйлгээтэй холбогдох мэдээллийг гаргаж өгөх боломжтой эсэхийг баталгаажуулах;

8.1.7 халхавч банк, санхүүгийн байгууллагатай бизнесийн харилцаа үүсгэхгүй;

8.1.8 хэрэв корреспондент харилцаа банк, санхүүгийн байгууллага нь дансаа халхавч банк, санхүүгийн байгууллага ашиглахыг зөвшөөрдөг бол түүнтэй корреспондент харилцаа үүсгэхээс татгалзах.

8.2 МэҮЭ нь энэ журмыг хэрэгжиж эхлэхээс өмнө үүсгэсэн корреспондент харилцааг эргэн нягталж, энэ журамд нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## ЕС. ШИНЭ ТЕХНОЛОГИ

9.1 МУТСТ тухай хуулийн 5.5-д зааснаар шинэ технологи ашиглан хийгдэж буй гүйлгээнээс үүдэн гарах МУТС эрсдэлийг бууруулах үүднээс дараах арга хэмжээг авна:

9.1.1 шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, бизнесийн шинэ харилцааны МУТС эрсдэлийг үнэлэх, шинэ технологи ашигласнаар одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний МУТС эрсдэл хэрхэн өөрчлөгдөхийг үнэлэх;

9.1.2 шинэ технологи нэвтрүүлснээс үүдэх МУТС эрсдэлийг бууруулах, үр нөлөөг нь багасгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

## АРАВ. ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ

10.1 МэҮЭ нь гадаад цахим шилжүүлэг хийхдээ хүлээн авагч болон дамжин өнгөрөх банк, санхүүгийн байгууллагад шилжүүлэгч ба хүлээн авагчийн мэдээлэл тодорхой байхаар шилжүүлгийн цахим зурваст (message) тусгана. Шилжүүлгийн цахим харилцаа дараах мэдээллийг агуулна:

10.1.1 шилжүүлэгчийн овог нэр;

10.1.2 шилжүүлэгчийн гүйлгээ хийхэд ашигласан дансны дугаар;

10.1.3 шилжүүлэгчийн хаяг эсхүл албан ёсны баримт бичгийн дугаар, эсхүл төрсөн огноо, төрсөн газар;

10.1.4 хүлээн авагчийн нэр, гүйлгээ хийхэд ашигласан дансны дугаар.

10.2 МэҮЭ нь 10.1-д заасан шаардлагыг хангаагүй цахим шилжүүлгийг хийхээс татгалзана.

10.3 Хэд хэдэн харилцагчийн гадаад цахим шилжүүлгийг багцлан, багц шилжүүлэг хэлбэрээр шилжүүлж байгаа тохиолдолд энэ журмын 10.1-д заасан шаардлагын шилжүүлэгчтэй холбоотой хэсгийг бүрэн хангах шаардлагагүй. Хүлээн авагч банк, санхүүгийн байгууллагад тухайн гүйлгээтэй холбоотой дүн шинжилгээ хийх боломжийг хангах үүднээс уг багц гүйлгээний шилжүүлэгчдийн мэдээллийг лавлахад ашиглах дахин давтагдахгүй дугаарыг хүргүүлнэ. Багц шилжүүлэг хийхэд хүлээн авагчийн мэдээлэлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

10.4 МэҮЭ нь МУТС эрсдэлийг бууруулах зорилгоор харилцагчийн тогтмол хийдэг, тогтсон цахим шилжүүлгээс ялгаатай цахим шилжүүлгийг багц шилжүүлэгт хамруулахгүй байхад анхаарна.

10.5 Дотоодын цахим шилжүүлгийг (зээлийн болон төлбөрийн карт ашиглан хийсэн гүйлгээг хамарна) хийж буй МэҮЭ цахим шилжүүлгийн зурваст дараах мэдээллийг хавсаргана:

10.5.1 шилжүүлэгчийн бүрэн мэдээлэл эсхүл гүйлгээний маягтыг эсхүл

10.5.2 зөвхөн шилжүүлэгчийн дансны дугаар, хэрэв дансгүй харилцагч бол шилжүүлэгчийн мэдээллийг лавлахад ашиглах дахин давтагдахгүй дугаарыг цахим зурвас эсхүл гүйлгээний маягтад тусган хүлээн авагчийн банк, санхүүгийн байгууллагад хүргүүлнэ.

10.6 Дотоодын цахим шилжүүлэгт шилжүүлэгчийн бүрэн мэдээллийг цахим зурваст хавсаргаагүй тохиолдолд цахим шилжүүлгийг хүлээн авсан МэҮЭ болон СМА цахим шилжүүлгийг хийсэн МэҮЭ-ээс шилжүүлэгчийн мэдээллийг авах хүсэлт гаргаж болно. Цахим шилжүүлгийг хийсэн МэҮЭ нь дээрх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор шилжүүлэгчийн талаарх өөрт байгаа мэдээллийг гаргаж өгнө.

10.7 Гадаад цахим шилжүүлгийг дамжуулан өнгөрүүлж байгаа МэҮЭ нь шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл болон шилжүүлэгтэй холбоотой бусад бүх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгална.

10.8 МэҮЭ нь цахим шилжүүлгийг хийх, дамжуулах, зогсоох, татгалзах эсэхийг шийдэх эрсдэлд суурилсан үр дүнтэй хяналтын тогтолцоотой байна. Энэ хяналтын тогтолцоо нь гүйлгээг СГ-ний тайлангаар СМА-нд мэдээлэх, бизнесийн харилцааг зогсоох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тусгайлан хяналт тавих бодлого, журамтай нийцсэн байна.

10.9 Цахим шилжүүлгийг хүлээн авсан МэҮЭ нь шилжүүлгийг хүлээн авч буй харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийх үүрэгтэй. ХТМ үйл ажиллагааны хүрээнд

цуглуулсан баримт, мэдээлэл болон цахим гүйлгээтэй холбоотой бүх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалах үүрэгтэй.

#### АРВАН НЭГ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ

11.1 МэҮЭ нь МУТС тухай хуульд заасан ХТМ үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн тохиолдолд уг гуравдагч этгээд нь ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан бүх баримт, мэдээллийг МэҮЭ-д гаргаж өгөх боломжтой байх шаардлагатай.

11.2 Гуравдагч этгээдийн хийж буй ХТМ үйл ажиллагаа нь МУТС-тэй тэмцэх тухай хууль тогтоомжоор тавигдаж буй шаардлагад нийцсэн байна.

11.3 ХТМ үйл ажиллагааг хийж буй гуравдагч этгээд нь МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд эрх бүхий байгууллагаас хяналт, шалгалтад хамрагддаг этгээд байна.

11.4 МэҮЭ-ийн өмнөөс ХТМ үйл ажиллагааг хийж буй гуравдагч этгээд нь ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан баримт, материалыг МУТС-тэй тэмцэх тухай хууль болон энэ журамд заасан мэдээллийг хадгалах шаардлагад нийцүүлэн хадгална.

#### АРВАН ХОЁР. ГАДААД ДАХЬ САЛБАР, НЭГЖ БОЛОН ОХИН КОМПАНИ

12.1 МэҮЭ нь гадаадад салбар нэгж болон дийлэнх хувьцааг нь эзэмшдэг охин компанитай бол тухайн улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээс гадна энэхүү журамд заасан шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллана. Хэрэв тухайн орны хууль тогтоомж энэхүү журмын хэрэгжилтэд аливаа шалтгаанаар саад болж байвал энэ талаар дотоодын хяналт зохицуулалтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

#### АРВАН ГУРАВ. САЛБАРЫН ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ, ЗААВАР

13.1 МУТС-тэй тэмцэх тухай хууль болон энэхүү журмын хэрэгжилтийг хангуулахад туслах зорилгоор тухайн салбарт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагаас МэҮЭ-ийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын онцлогт нийцүүлсэн тусгай зөвлөмж, зааврыг боловсруулан гаргаж болно.

#### АРВАН ДӨРӨВ. ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

14.1 МэҮЭ нь 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

14.2 МэҮЭ нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол МэҮЭ нь 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

14.3 МэҮЭ нь СГ-ний тайланг мэдээлэх үүрэгтэй ажилтны аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хамгаалах нөхцлийг хангаж ажиллана.

14.4 СМА нь хүлээн авсан СГ-ний тайлан, БМГ-ний тайлан, ГТТГ-ний тайлантай холбоотой статистик мэдээллийг улирал бүр Монголбанкны цахим хуудсанд байршуулна.

14.5 Энэ журмын 14.1, 14.2-т заасан гүйлгээг мэдээлэхтэй холбоотой журам, зааврыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

## АРВАН ТАВ. ХАРИУЦЛАГА

15.1 МэҮЭ СМА-нд мэдээлсэн тайлан, түүнтэй холбоотой нэмэлт мэдээллийн үнэн, зөв, бодит байдлыг хариуцана.

15.2 МэҮЭ, түүний удирдлага, захирал, ажилтан санаатайгаар худал мэдээлэл өгсөн эсхүл тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг гаргаж өгөөгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

15.3 Энэхүү журмыг заалтыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.